



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 5/50

Хэрлэн сум

Ажил хавсруулан гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.2, 50.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэнбаян-Улаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Хүрэлбаатар нь өөр ажилд шилжин томилогдсон тул тус сургуулийн багш Д.Солонгыг 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн захирлын үүргийг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг тосгоны Захирагч /С.Баясгалан/-д даалгасугай.

3. Захирлын ажлыг хавсран гүйцэтгэх Д.Солонгод үндсэн цалингаас нь 40 хувиар тооцон нэмэгдэл хөлс олгохыг сургуулийн нягтлан бодогч /Н.Анхбат/-д зөвшөөрсүгэй.

4. Захирлын ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА